



“АСБИ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТООЛЛОГЫН КОМИССЫН ТОГТООЛ

2021 оны 04 сарын 21 өдөр

Дугаар 01.

Улаанбаатар хот

Компанийн Хувьцаа Эзэмшигчдийн 2021 оны ээлжит хурал
хүчин төгөлдөр болсныг батлах тухай

Компаний тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1 дэх заалт, 2021 оны 4 дүгээр сарын 21-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын дүнг тус тус үндэслэн **ТОГТООХ** нь:

1. “АСБИ” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн дэлгэрэнгүй судалгаанд багтсан нийт 63,456 ширхэг хувьцаа эзэмшдэг 57 хувьцаа эзэмшигчдээс 4 хувьцаа эзэмшигч холбогдсон нь нийт саналын эрхтэй хувьцааны 94.03% (59,670 ширхэг) болж Хувьцаа Эзэмшигчдийн Хурал хуралдуулах ирц бүрдэж, хурал хүчин төгөлдөр болсныг зөвшөөрч баталсугай.

ТООЛЛОГЫН КОМИССЫН



ХЯАМ

Б.ДОРЖСҮРЭН

“АСБИ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТООЛЛОГЫН КОМИССЫН ШИЙДВЭР

2021... оны 04 сарын 21 өдөр

Дугаар 02

Улаанбаатар хот

Компанийн Хувьцаа Эзэмшигчдийн хурлаар хэлэлцсэн асуудал тус бүрийн саналын дүнг нэгтгэн батлах тухай

Компаний тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1 дэх заалт, 2021 оны 4 дүгээр сарын 21-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын дүнг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Хувьцаат Компанийн дүрмийн үлгэрчилсэн загварыг удирдлага болгох шийдвэрийн хүрээнд компанийн дүрмийг шинэчилэн батлах талаархи санал хураалтанд 100% зөвшөөрсөн саналтай байх тул шийдвэрийг хүчинтэйд тооцсугай.
2. Компанийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийгдсэн хараат бус аудиторын дүгнэлт болон үйл ажиллагааны тайлангийн талаархи ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэн батлах, эсэх: Санал хураалтын дүнгээр 100% зөвшөөрсөн тул шийдвэр хүчинтэйд тооцсугай.
3. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох санал хураалтын дүнгээр зөвшөөрсөн 100% байх тул шийдвэр хүчинтэйд тооцсугай.
4. Гүйцэтгэх удирдлага болон ТУЗ-ийн 2021 оны зардлын төсөв батлах санал хураалтын дүнгээр зөвшөөрсөн 100% байх тул шийдвэр хүчинтэйд тооцсугай.

ТООЛЛОГЫН КОМИССЫН
ДАРГА



Б.ДОРЖСҮРЭН



“АСБИ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2021 оны 04 сарын 21 өдөр

Дугаар 01

Улаанбаатар хот

Компанийн дүрэм шинэчилэн батлах тухай

Монгол улсын Компаний тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.1 дахь заалт, 2021 оны 04 сарын 21-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын дүнг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “АСБИ” ХК-ийн дүрмийг Санхүүгийн зохицуулах хорооны 74-р тогтоолын дагуу шинэчилэн баталсугай.
2. Шинэчилсэн дүрмийг үйл ажиллагаандаа баримтлан ажиллахыг гүйцэтгэх захирал Л.Сүмбандад даалгасугай.
3. Энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангах, шинэчилсэн дүрмийг Санхүүгийн зохицуулах хороо болон УБЕГ, бусад эрх бүхий байгууллагад бүртгүүлэхийг Ц.Хадаа /МП81053161/-д үүрэг болгосугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ХУРЛЫН ДАРГА



Д.ЛХАГВАСҮРЭН



“АСБИ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2021 оны 04 сарын 21 өдөр

Дугаар 02

Улаанбаатар хот

Компанийн 2020 оны үйл ажиллагааны тайлан болон санхүүгийн
тайланд өгсөн ТУЗ-ын дүгнэлтийг батлах тухай

Монгол улсын Компаний тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх заалтыг удирдлага болгон АСБИ ХК-ийн 2020 оны жилийн үйл ажиллагааны тайлан болон санхүүгийн тайлантай танилцаж, Төлөөлөн удирдах зөвлөлөөс өгсөн дүгнэлтийг хэлэлцсэний үндсэн дээр 2021 оны 4 дүгээр сарын 21-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын дүнг үндэслэн ТОГТООХ нь:

1. “АСБИ” ХК-ийн 2020 оны үйл ажиллагааны тайлан болон санхүүгийн тайлангийн талаар “Хангалттай” гэж дүгнэсэн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дүгнэлтийг зөвшөөрч баталсугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ХУРЛЫН ДАРГА



D. Lkhagvasuren
Д.ЛХАГВАСҮРЭН



“АСБИ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2021 оны 04 сарын 21 өдөр

Дугаар 03

Улаанбаатар хот

Компанийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн
Хараат бус аудиторын тайланд өгсөн ТУЗ-ын дүгнэлтийг батлах тухай

“АСБИ” ХК-ийн 2020 оны санхүүгийн тайланд хийсэн хараат бус аудиторын тайлантай танилцаж, Төлөөлөн удирдах зөвлөлөөс өгсөн дүгнэлтийг хэлэлцсэний үндсэн дээр 2021 оны 4 дүгээр сарын 21-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын дүнг үндэслэн ТОГТООХ нь:

1. “АСБИ” ХК-ийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийгдсэн хараат бус аудиторын тайланд өгсөн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дүгнэлтийг зөвшөөрч баталсугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ХУРЛЫН ДАРГА



D. Jhaagvasuren
Д.ЛХАГВАСҮРЭН



“АСБИ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2021 оны 04 сарын 21 өдөр

Дугаар 04

Улаанбаатар хот

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийг
сонгох тухай

Монгол улсын Компаний тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7 дахь хэсэг, 77 дугаар зүйлийн 77.2, 77.3 дахь хэсэг, 2021 оны 4 дүгээр сарын 21-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын дүнг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Компанийн ТУЗ-ийн гишүүнийг 9 хүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулж дор дурьдсан хүмүүсийг ажиллуулахаар баталсугай.

ТУЗ-ын ердийн гишүүнд

- 1.1 Д.Лхагвасүрэн
- 1.2 Л.Сүмбанд
- 1.3 Ч.Дащцэрэн
- 1.4 С.Буман-Эрдэнэ
- 1.5 Б.Доржсүрэн
- 1.6 Л.Түвшинзаяа

ТУЗ-ын хараат бус гишүүнд

- 1.7 Э.Буянтогтох
- 1.8 Л.Нямдаваа
- 1.9 Ц.Хадаа

2. Компанийн үр ашгийг дээшлүүлж, үйл ажиллагааг идэвхижүүлэх, менежментийг сайжруулах, Гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагааг хянаж, туслах чиглэлээр идэвхи гарган ажиллахыг ТУЗ-д даалгасугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ХУРЛЫН ДАРГА




Д.ЛХАГВАСҮРЭН



“АСБИ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2021 оны 04 сарын 21 өдөр

Дугаар 05

Улаанбаатар хот

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2021 оны төсөв батлах тухай

Монгол улсын Компаний тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.13 дахь заалт, 62.1.15 дахь заалт, 2021 оны 4 дүгээр сарын 21-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын дүнг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “АСБИ” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөл болон Гүйцэтгэх удирдлагын 2021 оны төсвийг 8,000,000 /найман сая/ төгрөгөөр тогтоосугай.

2. Төсвийн зардалд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн даргад даалгасугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ХУРЛЫН ДАРГА




Д.ЛХАГВАСҮРЭН